

## МОНГОЛ УЛСЫН ЯДУУРЛЫН ТӨРХ БА ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ ТАНДАЛТ СУДАЛГАА ХЯТАД УЛСЫН ТУРШЛАГААС

*А.Батцэцэг\**

*Н.Алтан\*\**

***Abstract:** Poverty in Mongolia is one of the most important social issues in the country. The government and relevant agencies have been active in implementing these measures, but the results have not been very successful. China, on the other hand, is the first country in the world to lift about 1.3 million people out of poverty each year. It is possible for Mongolia to learn from China's experience in poverty reduction, develop a comprehensive poverty reduction policy tailored to Mongolia's national situation, and explore the right ways to reduce poverty. Following the completion of Mongolia's first Millennium Development Goal poverty reduction plan, the poverty rate in 2015 was twice as high as in 2010, but did not reach the expected target. In 2016, the "Sustainable Development Plan 2030" was implemented and poverty was reduced, but poverty reduction remains a priority. Poverty remains a major problem in Mongolia, and at the same time, poverty reduction has become a benchmark for measuring people's public performance.*

***Key words:** Reduction of Poverty, Social Transition, Chinese Experience, Mongolian Poverty*

### Удиртгал

Монгол улсын ядуурал бол тус улсын хамгийн чухал нийгмийн тулгамдсан асуудал болоод байна. Засгийн газар болон холбогдох газрууд холбогдох арга хэмжээг идэвхтэй хэрэгжүүлсэн боловч үр дүн нь төдийлөн амжилттай хэрэгжихгүй байна. Харин Хятад улс жил бүр 1,3 сая орчим хүн ядуурлаас бүр мөсөн ангижирдаг бөгөөд НҮБ-ын Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлсэн анхны улс гэж хэлж болох юм. Судлаач миний бодлоор Монгол Улс Хятад улсын ядуурлыг бууруулах туршлагаас суралцаж, Монгол Улсын үндэсний нөхцөл байдалд тохирсон ядуурлыг бууруулах бодлого цогцоор нь боловсруулж, ядуурлыг бууруулах зөв арга замыг судлах бүрэн боломжтой гэж үзэж байна.

Монгол Улсын “Мянганы хөгжлийн зорилт” -ийн эхний зорилтын ядуурлыг бууруулах төлөвлөгөө хэрэгжиж дууссанаас харахад 2015 онд ядуурлын түвшин

\* ОУХНУС, ОУХ тэнхим, Ахлах багш, Доктор (Ph.D)

\*\* ӨМИС-МУСХ, Монгол Улсын ШУА-ОУХХ, зочин судлаач, Доктор (Ph.D)

2010 оныхоос 2 дахин их байсан ч хүлээгдэж буй зорилгодоо хүрч чадаагүй байна. Мөн 2016 онд “Тогтвортой хөгжлийн төлөвлөгөө-2030” хэрэгжиж, ядуурал буурсан боловч ядуурлыг бууруулах ажил мөн тулгамдсан ажил хэвээр байна. Ядуурал нь Монгол Улсын хувьд томоохон асуудал хэвээр байгаа бөгөөд үүнтэй зэрэгцэн ядуурлыг бууруулах ажил нь ард түмний төрийн ажлыг хэмжих жишиг болжээ.

## 1. Монгол улсын ядууралд байгаль цаг уур нөлөөлөх нь

Ядуурал нь эдийн засгийн хөгжил, улс төрийн тогтвортой байдал, нийгмийн дэг журам, эрүүл мэндийн хөгжилд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Монгол Улсын ядуурал нь байгалийн гамшиг, нийгмийн тогтолцоо, төрийн бодлогын хэрэгжилт хангалтгүй байдгаас голчлон үүсдэг. Олон нийтийн өмчлөлийн үед ядуурлын суурь маш бага байсан бөгөөд бүх нөөцийг улсаас төлөвлөж хуваарилдаг байсан юм, мөн зах зээлийн эдийн засаг нь ардчиллын үед хэт хурдан явагдаж, бодлогын зохицуулалт хяналтаас гарч, туйлшрал бий болж, ядуурал эрс нэмэгдсэн. Мөн малчдын ядуурлын асуудлыг хэзээ ч үндсээр нь шийдвэрлэж байгаагүй. Хөдөөгийн ядуурал нь газрын цөлжилт, ган гачиг, цас зуд, үер ус зэрэг байгалийн гамшигтай шууд холбоотой байсаар байна.. Хотын ядуурал нь голчлон ажилгүйдэл эсвэл тогтворгүй орлогын хомсдолоос болсон хэвээр байна. 2018 оны статистикийн мэдээгээр Монгол Улсын хамгийн олон ядуу хүн амтай аймаг бол Говь Сүмбэр, Зүүн аймгууд, Хэнтий болон бусад алслагдсан аймгууд багтаж байна. 2005-2012 онуудад нийгмийн халамжийн үйлчилгээний цар хүрээг өргөжүүлж, ядуурлын хүрээг мөн 4% бууруулсан. Гэсэн хэдий ч 2014 оноос хойш амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур иргэдийн эзлэх хувь 2016 он гэхэд 21.6% - 29.6% болж өссөн бөгөөд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур буюу сарын орлого нь 146,000 төгрөг (379.2 юань) хүрэхгүй хүн ам 634,000-аас 970 орчим мянга болж өссөн байна. Ядуурлын шалтгаан нь голдуу бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настан, ганц бие эмэгтэйчүүд, дөрвөөс дээш хүүхэдтэй гэр бүл, ажилгүйдэл, цөөн малтай малчид байна<sup>3</sup>. Монгол улсад 3122 бүтэн өнчин, 33322 хагас өнчин хүүхэд бүртгэлтэй байна<sup>4</sup>. Монгол улсад өнөөдрийн байдлаар нийгмийн халамжийн байгууллагууд, залуучуудын агентлагууд, эмэгтэйчүүдийг дэмжих сангууд улам хүрээгээ тэлж байгаа хэдий ч олон хүүхэд хараа хяналтгүй байсаар энэ нь ядуурлыг бууруулах ажилд багагүй бэрхшээл хүндрэлийг авчирсаар байна.

Мөн Монгол улсад ядуурлын олон шалтгаан байдаг бөгөөд гол нь дараах шалтгаантай гэж бодож байна. Байгалийн гамшиг. Цас зуд, үер ус, хаврын хуурайшилт байгалийн гамшиг зэрэг цаг агаарын эрсдэлт хүчин зүйл бүхий өндөрлөг газарт Монгол Улс байрладаг. Нүүдэлчид буюу малчдын орон гэр,

<sup>3</sup> Дэлхийн банк, Монгол дахь ядуурлын байдлын шинж чанар [А] Үндэсний статистикийн газар, Өрхийн эдийн засаг, нийгмийн судалгаа 2007-2008 [С] Улаанбаатар, 2009

<sup>4</sup> Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2017-2018, Улаанбаатар, 2018

амьдрах орчин нь нэлээд эмзэг бөгөөд байгалийн гамшигт нэрвэгдвэл даруй нийгмийн эмзэг байдалд шилжихэд ойрхон байдаг.

**Нийгмийн орчин:** Аливаа нийгэмд гаднаас өөр өөр соёлын сэтгэлгээ тасралтгүй орж ирсээр байдаг тул тухайн нийгмийн гишүүд үзэл баримтлалдаа бүрэн дүүрэн төвлөрч чадахгүй байх ба түүнээс улбаалан шашинд толгойгоо хэт мэдүүлэх, багахан мөнгөө сүм хийдүүдэд хандив өргөх, Будда бурханд залбирч шүтсээр байгаа нь өнөөгийн Монголчуудын ядуурлын нэг шалтгаан болоод байна. Харин залуучуудын хувьд барууны үнэт зүйлс, амьдралын хэв маягт дуртай байх нь судлаач миний хувьд ажиглагдлаа. Монголын нийгмийн өөрчлөлтийн системийн шинэчлэлийн явцад засгийн газар нь нийгмийн тогтолцоог өөрчлөн шинэчилэхэд анхаарлаа хандуулж чадаагүй учир олон янзын соёлын тархалшилт, шашны урсгалууд олноор нэмэгдэж иргэдийн тархи угаалт ихээр явагдсан нь ядуурлын бас нэг шалтгаан болоод байна гэж үзэж байна.

**Ажилгүйдэл:** Монгол Улсын эдийн засгийн хөгжил удааширч, ажилгүйдлийн түвшин нэмэгдэж байна. “Монгол Улсын хүний хөгжлийн тайлангийн статистик” (2016) -д дурдсанаар ажилгүйдлийн түвшин 2014 онд 7.9% байсан бол 2017 онд 8.8% болж өссөн байна. 2018 онд 6.9% болж буурсан ч хүнд хэвээр байна<sup>5</sup>. Нэмж дурдахад Монгол улсын байгаль орчин харьцангуй эрс тэс, өвөл урт, хүйтэн байдагтай холбоотой. Ж нь: Олон барилга байгууламж, зам тээврийн ажил өвлийн улиралд зогсонги байдалд ордог тул улирлын чанартай ажилгүйдэл ихээр гардаг.

### Ядуурлыг хэрхэн бууруулах вэ?

Хэдийгээр Монгол Улсын эдийн засгийн тогтолцоо өөрчлөгдсөн хэдий ч нийгмийн цогц бодлого, нийгмийн хамгаалал болон халамж нь харилцан хамаарлын уялдаан дор зангидагдаж чадаагүй тул нийгмийн асуудал нь бүрэн тогтворжихгүй, нийгмийн тогтвортой байдалд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Энэ байдлыг засахын тулд засгийн газар болон холбогдох газрууд хууль эрх зүйн олон арга хэмжээг тасралтгүй сурталчилж, авч хэрэгжүүлж сайжруулахгүй бол ядуурлыг бууруулах олон арга хэмжээ хэрэгжүүлж ирсэн нь үр дүнгээ өгөхгүй байна. Статистикийн мэдээгээр 2019 оны 6-р сарын байдлаар Монгол Улс 952 даатгалыг санг нэвтрүүлж, даатгуулагчдын тоо 526,071 хүнд хүрсэн бөгөөд тэдгээрийн дотор “Даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох тухай хууль”<sup>6</sup>, “Нийгмийн даатгалын сангаас хөдөлмөрийн хохирол, мэргэжлээс шалтгаалсан өвчний татаас олгох тухай хууль”, “Нийгмийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж олгох тухай хууль”, “Нийгмийн даатгалын тухай багц хуулийг хэрэгжүүлэх нарийвчилсан журам” зэрэг нь ядуурлыг бууруулахад тодорхой үүрэг гүйцэтгэсэн гэж болно.

Монгол Улсад ядуурлыг бууруулах бодлогын хэрэгжилтийн талаар бодлого

<sup>5</sup> Дэлхийн банк, Монгол дахь ядуурлын байдлын шинж чанар [А] Үндэсний статистикийн газар, Өрхийн эдийн засаг, нийгмийн судалгаа 2007-2008 [С] Улаанбаатар, 2009

<sup>6</sup> Монгол Улсын Хүний хөгжлийн илтгэл [М], Монгол Улсын Засгийн газар, Улаанбаатар, 2016 он

боловсруулагчид ихэвчлэн үндэсний ашиг сонирхол, нийтлэг ашиг сонирхолд тулгуурлан бодлого боловсруулдаг бол бодлого хэрэгжүүлэгчид нь төсвийн дээд хэмжээг нэмэгдүүлэхэд тустай зорилтот байгууллагууд болох орон нутгийн болон хувийн ашиг сонирхолд тулгуурласан бодлогыг авч хэрэгжүүлдэг. Үүний үр дүнд бодлого хэрэгжүүлэгчид нь зорилтот бүлгүүд бодлогыг гажуудуулж, ядуурлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг таагүй, эсвэл хүлээгдэж буй зорилтоос гажсан байдалд хүргэж байна. Монгол Улсын Засгийн газар 1992 оны 10 сараас эхлэн гурил, үндсэн нэрийн хүнс болон талх, ахуйн хэрэглээний цахилгаан эрчим хүч, хотын тээврийн үйлчилгээний үнийг чөлөөт үнэ, тарифийн тогтолцоонд<sup>7</sup> шилжүүлсэн нь үнэ өсөх суурь хүчин зүйл болсон юм. Хэрэглээний бараа хомсдож, үнэ өсөхөд тухайн үеийн хуримтлалгүй, цалингаас цалингийн хооронд амьдарч байсан өрх, хувь хүмүүс нэн тэргүүнд өртсөн бөгөөд эмзэг эрсдэлтэй байдалд орж, улмаар ядуурахад хүрсэн байна.

Шилжилтийн үеийн өргөн хэрэглээний барааны хомсдолд хуучин ЗХУ-ын тусламж дэмжлэг хумигдсан зэрэг гадаад хүчин зүйл нөлөөлсөний зэрэгцээ өмч хувьчлалаас үүдэн бий болсон үндэсний үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн дампуурал зэрэг үндэсний шинжтэй дотоод хүчин зүйл давхар нөлөө үзүүлсэн юм. Шилжилтийн он жилүүдэд дурьдсан бэрхшээл, хүндрэлүүд улам бүр даамжрах төлөвтэй байсан тул Монгол Улс 1994 онд анх удаа Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж эхэлсэн боловч нийгэм, эдийн засагт эерэг үр нөлөөтэй байсангүй.

Зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээр хувь хүний амьдралын хэв маяг, үйл ажиллагаанд өөрчлөлт орсон. Чухамхүү “нийгмийн хөдөлгөөнт шинж идэвхжсэн энэ үед хувь хүмүүсийн хэрэгцээ (зах зээлийн нөхцөлд сайн сайхан амьдрах)-г янз бүрийн арга хэрэглүүр (биеэ дайчлан ажиллах, улсын өмч завших, бусармаг арга)-ээр гүйцэтгэж эхэлсэн байна<sup>8</sup>.

## 2. Яагаад Монгол Улсын ядуурлыг бууруулах ажил үр дүн багатай байна вэ?

Эдийн засгийн ажиллагаа тогтворгүй байна. Монгол Улсын эдийн засаг дотоод, гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр тогтвортой хөгжөөгүй, хэлбэлзэл ихтэй байсан (графикийг харна уу). 1990 оноос хойш шилжилтийн үед нийгэм эдийн засгийн хямралд орж, 20 р зууны дунд үеэс сайжирсан бөгөөд 1992 онд нийлээдгүй түвшинд унасан, эдийн засгийн өсөлтийн хурд -10%, 1993 онд эдийн засаг аажмаар сэргэж эхэлсэн, 1996 онд олон улсын зах зээл дээрх зэс, ноолуурын үнэ буурч, дотоод улс төрийн тогтворгүй байдлаас болж эдийн засаг дахин буурсан, 2008 онд олон улсын санхүүгийн хямрал болж орлого, зарлагын дарамт хүнд байсан бөгөөд огцом унасан байдалтай байлаа<sup>9</sup>. 2012 онд олон улсын ашигт малтмалын зах зээл

<sup>7</sup> МУЗГ. Засгийн газрын мэдээлэл. №1. Чөлөөт үнийн тогтолцоонд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай. Засгийн газрын мэдээлэл.УБ., 1992

<sup>8</sup> ШУА, 1995,17

<sup>9</sup> Монгол Улсын ажилгүйдэл, ядуурлыг бууруулах бодлого [М], Монголын засгийн газар, Улаанбаатар, 2019

сайн хөгжиж, эдийн засаг 17.3 болж өссөн бөгөөд 2016 онд олон улсын өрийн дарамт ихсэж түүхий эдийн экспортын хэмжээ буурснаас эдийн засгийн өсөлтийн хурд дөнгөж 1.2%, 2018 онд түүхий эдийн үнэ өндөрсөж нүүрсний экспорт гадаад хөрөнгө оруулалтыг сэргээж өсөлтийн үр дүнд эдийн засаг 6.9 болж өссөн байна<sup>10</sup>.

Хэдийгээр дотоодын үйлдвэрлэлийн нэгдмэл бүтэц, эдийн засгийн өсөлт нь ашигт малтмалын бүтээгдэхүүний ашиглалт, экспортын худалдаанд найдсан ч, бодлогын удирдамж, бодит нөхцөл хоорондын зөрүүгээс шалтгаалан Монгол Улсын эдийн засаг тогтвортой хөгжлийн үе шатанд орж чадахгүй байна.

Зураг 1.



Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2018

Удирдлагын тогтолцооны олон цоорхойноос болж ядуурлыг бууруулах сангууд боломжоо шавхаж дууссан. Ядуурлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлэх явцад байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа хангалттай ойр биш энэ нь бодлогын хэрэгжилтийн үр дүнд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Ядуурлыг бууруулах бодлогын хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй, хуучин тогтолцоо нь сул талуудтай, ядуурлыг бууруулах шинэ бодлого нь аажмаар явагдаж байгаа хэдий ч , үр дүн багатай ядуурлыг бууруулах төлөвлөгөөний хүлээгдэж буй зорилгод хүрэхгүй байна. Засгийн газар болон ядуурлыг бууруулах агентлагууд дээр дурдсан асуудлуудад анхаарлаа хандуулаагүй биш хандуулж байгаа хэдий ч салбаруудын бүтэцийн хувьд, менежментийн нарийн чанд байдал, уядаа холбоо, мэргэжилтэнгүүдийн хувьд туршлагагүй байдал болон бусад олон шалтгааны улмаас ядуурлыг бууруулах зарим сангууд үнэхээр үүгэг гүйцэтгэж чадахгүй байна.

Хөрөнгө оруулалтын орчин муу, хөгжлийн ядуурлыг бууруулах нь хэцүү байдаг. Халамжийн хэлбэрийн ядуурлыг бууруулах нь нийгмийн эмзэг бүлгийн хүмүүсийн ядуурлын асуудлыг үндсээр нь шийдвэрлэх боломжгүй

<sup>10</sup> Монгол Улсын ажилгүйдэл, ядуурлыг бууруулах бодлого [M], Монголын засгийн газар, Улаанбаатар, 2019

юм. Ядуурлыг бууруулах ажил нь нүүдэлчдийн соёлын онцлогт тохирсон байх ёстой, гадаадын туршлагыг хуулбарлах ёсгүй бөгөөд бодит хэрэгжилт дээр үндэслэн тус улсын ядуурлыг бууруулах ажлын чиг хандлага болох ядуурлыг бууруулах хөгжлийн замтай нийцэж байх юм. Мал аж ахуйг хөгжүүлэх нь эрсдэлтэй бөгөөд үр дүнд хүрэхэд удаан байдаг. Тиймээс энэ нь хөгжлийн ядуурлыг бууруулахад тодорхой бэрхшээлийг үүсгэсээр байна Хөдөлмөрийн зах зээлийн хөгжил, ашиглалт хангалтгүй байна. 1991 оноос хойш ядуурлыг бууруулах зорилгоор хөдөлмөрийн үйлчилгээг бий болгосон боловч сургалтын ажил нь бодит хэрэгцээ шаардлагаас хол байна.

### **3. Монгол улс Хятад улсын ядуурлыг бууруулах туршлагаас суралцаж, ядуурлыг бууруулах бодлогын уялдааг сайжруулах нь**

Сүүлийн жилүүдэд Хятадын засгийн газар нийт ядуусыг ядуурлаас ангижруулж, олон нийтийн оролцоотойгоор ядуурлыг бууруулах бодлогыг баримталж, ядуурал ихтэй гол муж хотууд, гол хүн амын ядуурлыг бууруулах арга хэмжээг бэхжүүлж, нийгмийн хамгааллын системийг тасралтгүй сайжруулж, ядуу иргэдийн амьдрах, хөгжих эрхийг баталгаажуулж ирсэн бөгөөд энэ Хятад маягийн ядуурлыг бууруулах үндсэн туршлага юм. Уг туршлага нь Монгол Улсын ядуурлыг бууруулах, хөгжлийн бодлогыг өөрчлөх, сайжруулахад чухал нөлөөтэй юм. Үүнд;

37 жилийн турш шаргуу хөдөлмөрлөсний эцэст 700 сая гаруй хөдөө тосгоны ядуу иргэд ядуурлаас ангижирч, бүх талаараа сайн сайхан амьдрах үндэс суурийг тавьсан юм<sup>11</sup>. Хятад бол дэлхийн хамгийн олон тооны ядуурлыг бууруулсан улс бөгөөд НҮБ-ын Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлсэн анхны улс юм. Энэ нь хүн төрөлхитөний түүхэн дэх хамгийн том үүрэг гүйцэтгэж, туйлын ядуурлыг арилгасан орон болсон юм.

Хятадын ядуурлыг бууруулах бодлого нь зүгээр нэг уламжлалт санхүүгийн асуудал биш юм. Үүнийг ойролцоогоор гурван ангилалд хувааж болно: Эхний ангилал нь Хятадын ядуурлыг бууруулах бодлогын үндэс, үндэс суурь болсон хөгжлийг дэмжих бодлого юм. Энэ бол ядууралд нэрвэгдсэн бүс нутгийн бүлгүүдийг орон нутгийн нөөцийг хөгжүүлэх, түүхий эдийн үйлдвэрлэлийг гол болгон эдийн засгийн бүтээн байгуулалтыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, дэмжих замаар өөрийгөө хөгжүүлэх чадавхийг бэхжүүлэх бодлого юм. Бодлогын объект нь гол төлөв хот, хөдөөгийн ядуу иргэд байдаг. Бодлогын зорилго нь эдгээр хүмүүсийг тохиромжтой ажил эрхэлж, орлого олсны дараа ядуурлаас ангижрахад сурталчлах явдал юм. Хоёрдахь ангилал нь нийгмийн хамгааллын бодлого, үүнд хот, хөдөөг хамарсан эмнэлгийн аюулгүй байдал, тэтгэврийн аюулгүй байдлын бодлого орно. Уг функц нь ядуучуудын наслалт, өвчин, тахир дутуу, ажилгүйдэл,

<sup>11</sup> Үндэсний статистикийн газар, хөдөө аж ахуйн судалгааны баг. Хятадын хөдөөгийн ядуурлын стандартын судалгаа-Судалгааны бүлгийн судалгааны тайлан [J]. Статистикийн судалгаа, 1990 (6): 37-42.

төрөлт, нас баралт, гамшиг, амьдралын хүнд хэцүү үеийн тусгай хэрэгцээг хангахад хангалттай хөрөнгө зарцуулах явдал юм. Үргэлж сайжирч буй нийгмийн хамгааллын механизм нь ядуусыг ядуурлаас ангижрах замыг ихээхэн хааж байжээ. Гурав дахь ангилал нь хөдөө аж ахуйг дэмжих, гэр бүл төлөвлөлт, хөдөө орон нутаг руу чиглэсэн шинжлэх ухаан, технологи, хөдөө орон нутагт хүргэх цахилгаан хэрэгсэл, “тосгоноос тосгон руу чиглэсэн төсөл”, жижиг зээл, хөдөө орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зэрэг хөдөө орон нутагтай холбоотой ядуурлыг бууруулах бодлого юм. Ядуурлыг олон янзын өнцгөөс харж янз бүрийн бодлогыг багц хэлбэрээр хамтран хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Доорх гурван төрлийн бодлогын харилцан туслалцаа, уялдаа холбоонд үндэслэн Хятад улсын ядуурлын туйлын асуудлыг эрс багасгасан гэж үзэж болно.

Үүнд, ядуурлыг бууруулах арга, аргууд нь:

1. Ядуурал ихтэй бүс нутаг, хошууг тодорхойлох.

Хятад бол хүн ам ихтэй, эдийн засгийн суурь сул хөгжөөгүй хоцрогдсон хөдөө орон нутаг ихтэй хөгжиж буй орон юм. Ядуурлыг бууруулах гол мужуудыг тодорхойлох нь гол бэрхшээлийг шийдвэрлэхэд тустай бөгөөд мөн ядуурлыг бууруулах зорилтыг тодорхой болгох явдал юм.

2. Ядуурлыг бууруулах ажлын хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэх.

Хятадын засгийн газар ядуурлыг бууруулах, улсаа хөгжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулахад 1986 оны 6-р сард Төрийн Зөвлөлийн Ядуурлын бүсэд эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх хэсэг<sup>12</sup> (1993 онд Төрийн Зөвлөлийн Ядуурлыг бууруулах, улсыг хөгжүүлэх тэргүүлэх бүлэг болгон өөрчилсөн) байгуулагдсан нь орон нутгийн холбогдох агентлагуудыг шатлан удирдах Төв газрын шууд харьяа бүх муж, автономит муж, хотын захиргааг хариуцаж ажилладаг гол хүмүүс нь ядуурлыг бууруулах ажлыг бие даан хариуцдаг. Хятадын Засгийн газар ядуурлыг бууруулах төсвийн дэмжлэгийг жил бүрийн эхэнд бүх муж, автономит бүс, хотын захиргаанд жилд нэг удаа тарааж, түүнийг мужийн ард иргэдийн захиргаа нь зохион байгуулж төлөвлөж, хэрэгжүүлдэг байна<sup>13</sup>.

3. Хөгжилд чиглэсэн ядуурлыг бууруулах бодлого баримтлах.

Ядуурлыг бууруулах нь эдийн засгийн бүтээн байгуулалтад төвлөрсөн уламжлалт бус тусламжийн ядуурлыг бууруулах шинэчлэл юм. Энэ нь үйлдвэрлэлийн нөхцлийг сайжруулах, орон нутгийн нөөцийг хөгжүүлэх, түүхий эдийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, өөрийн чалавхиа нэмэгдүүлэх, өөрийгөө хөгжүүлэх чадварыг дээшлүүлэхэд ядууралд нэрвэгдсэн бүсийн боловсон хүчин,

<sup>12</sup> Рейнольдс. Микро эдийн засаг [М]. Бээжин, 1993: 32.

<sup>13</sup> Мартин Реворин, Ядуурлын харьцуулалт [М]. Бээжин: Бээжингийн их сургуулийн хэвлэл, 2005: 97.

хүмүүсийг дэмжих, урамшуулах явдал юм. Мөн ядуу тариачдыг хөдөлмөр эрхлэхэд нь хөрөнгө оруулахыг дэмжих, загасны аж ахуй ажлуулах, газар тариалангийн талбайн ажил, усны хамгаалалт, зам гэх мэт дэд бүтцийн бүтээн байгуулалтын төрөөс шаардагдах ажилд хөрөнгө бүрдүүлэх явдал юм.

#### **4. Монгол Улс ядуурлыг бууруулах дараах туршлагыг нэвтрүүлэх нь:**

Монгол Улс Хятадын ядуурлыг бууруулах туршлагыг нэвтрүүлж, аж үйлдвэрийг сайжруулах, аж үйлдвэрийг төрөлжүүлэн хөгжүүлэх, засгийн газрын хэлтсийн чиг үүргийг сайжруулах, хууль тогтоомжийн тогтвортой байдлыг хангах боломжтой юм.

Үүнд:

1. Ядуурлыг бууруулах төрийн ба төрийн бус байгууллагуудыг олноор байгуулж сайжруулах. Монгол Улсын онцлогт суурьласан ядуурлыг бууруулах олон улсын бодит загварыг дагаж мөрдөх, ялангуяа Хятад маягийн ядуурлыг бууруулах туршлагыг дагах, ядуурлыг бууруулах тусгай бодлого боловсруулах, ядуурлыг бууруулах төсөвт байгууллагуудыг бий болгох, боловсронгуй болгох нь ядуурлыг бууруулах бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэй гаргаж, үр дүнтэй хэрэгжүүлэхэд дөхөм болно.
2. Ядуурлыг бууруулах бодлого болон эдийн засгийн бодлогын уялдаа холбоог уялдуулах.

Санхүүгийн системийг сайжруулах, аж үйлдвэрийн сүлжээг бий болгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуусыг хөдөлмөр эрхлэх чадварт сургах зэрэг шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлэх нь ядуурлыг бууруулах үр нөлөөг тодорхой хэмжээгээр сайжруулж тэгснээр ядуу иргэдийн оршин тогтнох, хөгжих эрхийг баталгаажуулж аажмаар бүх нийтийн эрүүл мэндийн аюулгүй байдал, нийтийн халамжийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

3. Ядуурлыг бууруулах загварыг өөрчилж, зорилтот ядуурлыг бууруулах ажлыг хэрэгжүүлэх. Тусламжийн хэлбэрийн ядуурлыг бууруулах загвар нь засгийн газраас ядуус болон ядуу малчдад үзүүлэх төвлөрсөн бус тусламжийн материалыг хэлдэг бол хөгжлийн хэлбэрийн ядуурлыг бууруулах загвар нь орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжиж, малчдын орлогыг нэмэгдүүлэх, улмаар ядуурлаас гарах ядуурлыг бууруулах загварыг хэлнэ. Энэхүү өөрчлөлтөд хүрэхийн тулд нэгдүгээрт засгийн газар нь дэд бүтцийг бий болгох, мал аж ахуйг өөрчлөх чиглэлээр бэлчээрийн мал аж ахуй эрхлэх бүсэд тэтгэмж олгож, малчдыг үйлдвэрлэлийн арга хэлбэрээ өөрчлөхийг уриалж, мал сүргийг цаг агаарын эрсдэлт хүчин зүйлтэй ялангуяа хүйтэнд тэсвэртэй болгох чадварыг сайжруулах. Хоёрдугаарт, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр барих ажлыг зохион байгуулах, дурдсан жагсаалд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж буй малчдад зээлийн хүүгийн хөнгөлөлт буюу санхүүгийн дэмжлэг олгох. Цаашилбал, мал аж ахуйг



хөгжүүлэх эрсдлийг даван туулахын тулд даатгалын санг нэмэгдүүлэх нь зүйтэй юм. 2014 онд зөвхөн 14300 Монгол өрх малын даатгалд хамрагдсан нь дөнгөж 6.61% -ийг эзэлж байна. Засгийн газар даатгалын санг нэмэгдүүлбэл малчдын эрсдлийн түвшинг багасгаж мал аж ахуйн салбарын хөгжлийг тогтворжуулж, малчид нэг шөнийн дотор ядуурахаас урьдчилан сэргийлж ч болох юм. Эцэст нь ядуурлыг үр дүнтэй бууруулахын тулд хязгаарлагдмал санхүүгийн эх үүсвэрийг нааштай шийдэх, төрийн бодлогоо ядууралд өртсөн төрийн дэмжлэг шаардлагатай байгаа ядуус болон малчдад ашиглах ёстой бөгөөд “ тусламж, баталгаа, ядуурлыг арилгах” гэсэн холбоосоор айл өрх, ард түмэнд үнэн зөв ижил тэгш үйлчилж байх ёстой юм.

4. Малчдын зах зээлийн эдийн засаг, түүхий эдийн талаарх мэдлэгийг дээшлүүлж, тэдний мэргэн ухаан, хүсэл эрмэлзэлд туслахад анхаарлаа төвлөрүүлэх.

Нэгдүгээрт, Монголын малчид зах зээл, түүхий эдийн талаарх мэдлэг сул, мал аж ахуй эрхлэх, малын гаралтай бүтээгдэхүүний эргэлт тааруу байна. Малчид үндсэндээ “хэрэгцээнд зориулж зарж борлуулдаг”, өөрөөр хэлбэл, хэрэгцээт зүйлийг худалдаж авахын тулд малаа малын гаралтай бүтээгдэхүүний худалдааны зах дээр зарж борлуулдаг. Худалдах үнэ нь идэвхгүй байдаг. Малчдын бараа бүтээгдэхүүний мэдлэгийг дээшлүүлэхийн тулд юун түүрүүнд бүх шатны засгийн газрууд жил бүр мал аж ахуйн үйлдвэрлэлийн түвшинг нэмэгдүүлэх, нөөцийн тоог бууруулах чиглэлээр малчдыг сургах, чиглүүлэх ёстой. Хоёрдугаарт, телевиз, сонин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний эдийн засгийн мэдлэгийг суулгах, ялангуяа мал аж ахуйг зах зээлд хэрхэн борлуулах талаар сурталчлах, малчдад мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг арилжаалах амжилттай туршлагыг хуваалцаж ядуурлаас хэрхэн гарах зэрэг арга ухаанд суулгах. Гуравдугаарт, урам зориг өгөх, өөрийн чадамжинд тулгуурлаж ядуурлаас гарах чиглэлийг ухуулах сургалтын төвүүдийг байгуулах нь ядуусын болон ядуу малчдын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, зах зээлийн чиг баримжаатай үйл ажиллагааны талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд дэмжин туслах явдал юм.

### **Шилжилтийн үеийн ядуурлыг товч дүгнэх нь:**

Шилжилтийн дараах орнуудын нэгэн адил Монгол Улсад хүн амын гуравны нэгээс илүү хувь нь ядуурлын нүхэнд унасан бөгөөд ядуурлын түвшин хорь гаруй жилийн туршид 30 хувиас буухгүй байж ирсэн. Шилжилтийн дараах улс орнуудтай харьцуулахад ядуурлын түвшин сондгойрох хэмжээнд өндөр байгаагүй ч, бусад орнуудаас удаан хугацаанд буурахгүй, үргэлжилж байснаараа онцлогтой.

Монгол Улсын ядуурлын түвшин 2010 оноос хойш буурч ирснийг статистикийн байгууллагын судалгааны дүн илтгэж байна. Хүн амын эмзэг хэсэгт үзүүлж буй халамжийн бодлогод загвар хийгээд бүтцийн хувьд дорвитой шинэчлэл хийгдээгүй

ч, засгийн газраас хийсэн өргөн цараатай мөнгөн шилжүүлгийн бодлогууд ядуурлын түвшин буурахад тодорхой нөлөө үзүүлсэн талаар дүгнэж байна. Дэлхийн санхүүгийн хямрал нь хөгжиж буй олон оронд эдийн засгийн уналт авч ирээд зогсохгүй ядуусыг илүү их эрсдэлд оруулсан байдаг<sup>14</sup>. Харин, Монгол Улс 2009 оны дэлхийн эдийн засгийн хямралын үед халамжийн бэлэн мөнгөн шилжүүлэг хийх бодлогыг явуулж байсан нь ядуурлыг улам бүр даамжруулахгүйгээр авч гарсан, цаашилбал 2012 он хүртэл хэрэгжсэн дээрх бодлого нь цаашид ядуурал буурахад нөлөөлсөн гэж үзэх нь бий<sup>15</sup>. Эцэст нь ядуурал бол зөвхөн халамжийн бодлогоор буурдаг зүйл биш, эдийн засгийн өсөлт ядуурал ч бус, хөгжлийн асуудал, эдийн засаг өсч байхад түүний түвшин буурахгүй бол хөгжил явагдахгүй байна гэж үздэг. Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгийн төсөлд “эдийн засаг хурдацтай өсөж байсан жилүүдэд ядуурлын түвшин дорвитой буураагүй нэг шалтгаан нь баялгийн тэгш бус хувуулалт юм. Баялгийн хуваарилалтыг тэнцвэртэй болгоход дан ганц нийгмийн халамж, тэтгэмж хангалтгүй байна. Халамжийн тухайд тодорхой зорилтот бүлэг, зорилгод чиглээгүй бодлого үр дүнд хүрэхгүйг энэ чиглэлийн 70 гаруй арга хэмжээ харуулж байна” гэж хууль тогтоох байгууллагаас дүгнэжээ<sup>16</sup>. Түүнчлэн, эдийн засагчид “нийгмийн эмзэг байдал, ядуурлыг бууруулахад эдийн засгийн өсөлтийн үр шимийн ядуу иргэдэд дахин хуваарилах, ингэхдээ зөвхөн мөнгөн хэлбэрээр олгох тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн төрөл зүйл, хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарлаа хандуулсан нь нийгмийн эмзэг байдал ядуурлыг бууруулахад төдийлөн үр шимээ өгөөгүй” гэж үзжээ. Монгол дахь ядуус болон ядуу өрхүүд нийгмийн халамжийн тогтолцоонд ачаалал дарамт үзүүлсэн нийгмийн бүлэг, давхарга байгаагүй. Энэ нь халамж тэтгэмжийг нэг талаас нэн ядуу, үгээгүй ядууст гэхээсээ эмзэг бүлэгт хаягласан хөтөлбөрүүд зонхилон өгч байсантай, нөгөө талаас нийгмийн халамжийг хүн амын аргад суурилсан хэлбэрээр өгч байснаас ядууст чиглэсэн зорилтот хөтөлбөр хэлбэрээр олгож байгаагүйд оршино. Товчхон дүгнэхэд өнөөгийн халамжийн арга хэмжээнүүдэд өрхөд суурилсан хөтөлбөр бага хувийг эзэлж, хувь хүнд чиглэсэн тэтгэвэр тэтгэмж, тусламж давамгайл байдалтай байна.

Өнгөрсөн хугацаанд нийгмийн халамжийн тогтолцоонд бүхий л нийгмийн бүлэг давхаргууд нэгэн адил ачаалал болж ирснээрээ онцлог байна. Сүүлийн арван жилийн туршид нийгмийн бүхий л давхаргын ахмад, эмэгтэйчүүд, хүүхдүүд, нийгмийн халамжаас зохих үр шим хүртэж ирсэн бөгөөд ядуу болон нэн ядуу, үгээгүй ядуу өрхийн хүмүүст нийгмийн халамжийн тэтгэмжүүд бараг зарцуулагдаагүй байгаа нь анхаарал татаж байна.

Монгол Улсын нийт өрхийн 40.4 хувь буюу 306.8 мянган өрх нийслэл хотод оршин сууж, нэг өрхийн дундаж ам бүлийн тоо 3.9 болсон<sup>17</sup>. Нэг өрхийн ам бүлийн

<sup>14</sup> (Бойроу.Ж, 2009)

<sup>15</sup> Хаахнх яам 2016

<sup>16</sup> УИХТГазар 2015

<sup>17</sup> Дэлхийн банк, Монгол дахь ядуурлын байдлын шинж чанар [А] Үндэсний статистикийн газар, Өрхийн эдийн засаг, нийгмийн судалгаа 2007-2008 [С] Улаанбаатар, 2009

тоо 1990-ээд оны дунд үеэс эхлэн буурсаар 4.4 болсон ньсүүлийн жилүүдэд тогтвортой байсан бөгөөд 2011 онд буурч 3.9 болсон байна<sup>18</sup>. Нийт өрхийн 2.6 хувь буюу 7,833 нь 8 ба түүнээс дээш ам бүлтэй бол 6,959 өрх 16хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхүүд байна<sup>19</sup>. 2011 онд өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо 24.4 мянга болж өмнөх оноос 1,189хүнээр буюу 4.6 хувиар буурчээ<sup>20</sup>.

Сүүлийн 5 жилд нийслэл хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнөөс шууд шалтгаалж гэрхорооллын өрх, хүн амын тоо эрс өсч байна.Нийслэл хотод аймгаас шилжин ирэгсдийн болон шинээр тусгаарласан өрхийнорлогын түвшин, төвлөрсөн дэд бүтэцтэй орон сууцны хүрэлцээгүй байдлаас голчлоншалтгаалж Улаанбаатар хотын гэр хороолол тодорхой төлөвлөлтгүйгээр тэлж байнаМонгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 45.1 хувь буюу бараг хоёр хүн тутмын нэг нь нийслэл хотод оршин сууж байна. Нийслэлийн хүн амын 58.2% нь Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан зэрэг захын дүүрэгт, 36.8% нь Чингэлтэй, Сүхбаатар, Баянгол зэрэг төвийн дүүрэгт, үлдсэн 5% нь Налайх, Багануур, Багахангай зэрэг алслагдсан дүүрэгт тус ус амьдардаг байна<sup>21</sup>.

Монгол гэрт амьдардаг нийт өрхийн 6.2 хувийг сүүлчийн нэг жилд шилжин ирсэн өрх,бусад сууцад амьдардаг өрхийн 4.8 хувь нь нийслэл хотод 2010 онд шилжин ирсэн өрх байна. Байшин сууцанд амьдардаг нийт өрхийн 3.1 хувь хувийг сүүлчийн нэг жилд шилжин ирсэн өрх эзэлж байгаа нь Улаанбаатар хотод шилжин ирсэн жилдээ багтаж байшин орон сууц худалдан авах нь бага байгааг харуулж байна.

Нийслэл хотод хүн амын цахилгаан эрчим хүчний хангамжийг төвлөрсөн болонтөвлөрсөн бус байдлаар шийдсэн нь бодитой үр дүнд хүрчээ.Нийслэлийн хэмжээнд 5000 гаруй ядуу өрх цахилгаангүй байна.Харин орон сууцны халаалт, ариун цэврийн байгууламж зэрэг үзүүлэлтүүдийн хувьдучир дутагдалтай байгаа нь хүн амын шилжих хөдөлгөөнтэй шууд холбоотой бөгөөд эдгээрсалбарт төр засгийн зүгээс нэмэлт бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Байшинд амьдардаг өрхийн 55.0 хувь төвлөрсөн халаалтын системд холбогдсон байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 5.4 пунктээр буурсан байна.Харин иргэд сууцаа ердийн галлагаагаар халааж байгаа хувь нийслэлд 6.6 пунктээр нэмэгдсэн байна.

Улсын дунджаар нэг өрхийн сарын дундаж зарлагын 87.9 хувийг мөнгөн зарлага эзэлж байхад нийслэлийн хувьд нэг өрхийн сарын дундаж зарлагын 96.9 хувийг мөнгөн зарлага эзэлж байна<sup>22</sup>.

<sup>18</sup> Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2017-2018, Улаанбаатар, 2018

<sup>19</sup> Монгол Улсын Хүний хөгжлийн илтгэл [М], Монгол Улсын Засгийн газар, Улаанбаатар, 2016

<sup>20</sup> Дэлхийн банк, Монгол дахь ядуурлын байдлын шинж чанар [А] Үндэсний статистикийн газар, Өрхийн эдийн засаг, нийгмийн судалгаа 2007-2008 [С] Улаанбаатар, 2009

<sup>21</sup> Монгол Улсын ажилгүйдэл, ядуурлыг бууруулах бодлого [М], Монголын засгийн газар, Улаанбаатар, 2019

<sup>22</sup> Монгол Улсын ажилгүйдэл, ядуурлыг бууруулах бодлого [М], Монголын засгийн газар, Улаанбаатар, 2019

Монгол Улсад 1991 оноос хойш хүн амын амьжиргааны доод түвшин буюу хүний нэнтэргүүний зайлшгүй хүнсний болон хүнсний бус хэрэглээг (ядуурлын шугам) мөнгөн хэлбэрээр илэрхийлсэн хэмжээг 22 удаа шинэчлэн тогтоосон<sup>23</sup>.

## ДҮГНЭЛТ

Өнөөгийн халамжийн арга хэмжээнүүдэд өрхөд суурилсан хөтөлбөр өчүүхэн бага хувийг эзэлж байгаагийн зэрэгцээ хувь хүнд чиглэсэн тэтгэвэр тэтгэмж, тусламжууд давамгайлах шинжтэй байна. Ялангуяа ядуусын зан үйлд эерэг хөшүүрэг болохуйц нөхцөлт мөнгөн тэтгэмж хэрэгжиж байгаагүй, халамжийн мөнгөн тэтгэмжүүдийн бодит хэмжээ бага тул өрхийн худалдан авах чадварт нөлөөлөх байдал ихээхэн доогуур байгаа юм.

Төрийн нийгмийн халамжийн байгууллага болон төрөөс бусад халамжийн байгууллагуудын мэдээлэл харилцаа хийгээд уялдаа холбоо хангалтгүй байгаа нь ядуурлыг бууруулах бодит боломжийг хазаарлаж, үр нөлөөг хязгаарлаж ирсэн гэж дүгнэж болно. Хятад улсын жишээн дээр харахад орон нутагт иргэдэд газар эзэмшүүлэх замаар хөдөө аж ахуй газар тариаланг дэмжиж, ядуурал ажилгүйдлийг бууруулах бодлого хэрэгжүүлсэн нь ядуурлыг богино хугацаанд их тоогоор гаргасан амжилт олсон байна. Ингэснээр ард иргэд нь эзэмшлийн газартаа газар тариалалт болон мал аж ахуй хөгжүүлж, гар урлал, хатгамал зэрэг жижиг үйлдвэрлэлээрээ тогтмол орлогын эх үүсвэртэй байх боломжтой байгаа юм. Ингэснээрээ хотруу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, сааруулах арга хэмжээ авч хотжилтын ядуурлаас сэргийлж чадсан мөн хавтгайрсан нийгмийн халамжаас зайлсхийж ядуу өрх, иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өөрсдийнх нь чадварыг дайчилж тогтмол ажилтай орлоготой болгосон төдийгүй орлогын эх үүсвэрийг дэмжих үүднээс гурван жилийн хугацаатай 50 мянган юанийн зээлийг ямар ч хүүгүй олгодог зэрэг ядуу өрх болон ядуу иргэдийн амьжиргаанд шууд нөлөөлж буй туршлага олон байна.

## НОМ ЗҮЙ

Дэлхийн банк, Монгол дахь ядуурлын байдлын шинж чанар, Үндэсний статистикийн газар, Өрхийн эдийн засаг, нийгмийн судалгаа 2007-2008, Улаанбаатар, 2009

Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2017-2018, Улаанбаатар, 2018

Ши Жиньпин, Ядуурлаас ангижрах нь, Strait Publishing Group, 2014 он

Монгол Улсын Хүний хөгжлийн илтгэл, Монгол Улсын Засгийн газар, Улаанбаатар, 2016 он

Монгол Улсын ажилгүйдэл, ядуурлыг бууруулах бодлого, Монголын засгийн газар, Улаанбаатар, 2019 он

Үндэсний статистикийн газар, хөдөө аж ахуйн судалгааны баг. Хятадын хөдөөгийн ядуурлын стандартын судалгаа-Судалгааны бүлгийн

<sup>23</sup> Монгол Улсын Хүний хөгжлийн илтгэл [М], Монгол Улсын Засгийн газар, Улаанбаатар, 2016

- судалгааны тайлан [J]. Статистикийн судалгаа, 1990 (6): 37-42.
- Рейнольдс. Микро эдийн засаг [М]. Бээжин: Арилжааны хэвлэл, 1993: 32.
- Сун Жианжун. Тайван дахь нийгмийн тусламжийн бодлогын хөгжлийн талаар хийсэн судалгаа [М]. Тайпэй: Шийинг хэвлэлийн газар, 2002: 64.
- Мартин Реворин. Ядуурлын харьцуулалт [М]. Бээжин: Бээжингийн их сургуулийн хэвлэл, 2005: 97. 1967: 86-94.
- Юэ Шиминг, Ли Ши, Ван Пингпин гэх мэт. Хятадын хөдөөгийн ядуурлын хэтийн төлөв [М]. Бээжин: Эдийн засгийн шинжлэх ухааны хэвлэл, 2007: 74
- Нийгмийн хамгаалал, онол арга зүй, туршлага, харьцуулалт. Дагвадорж. Ч. (2004). Улаанбаатар: Хөх судар хэвлэл.
- Засгийн газрын мэдээ. (1993), 6.
- МЗХ. (2006). Монголын залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал. Үндэсний илтгэл.
- Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар. (2005). Retrieved from Улаанбаатар:
- Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар судалгааны тайлангаас. (2006). Retrieved from
- Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиг хандлага, үр дагавар судалгааны тайлан. (2008). Retrieved from Ulaanbaatar:
- НАМЗХ. (1993). Залуучуудын талаар баримтлах төрийн бодлого: суурь судалгааны урьдчилсан тайлан Retrieved from
- НАМЗХ. (2013). Залуучуудын талаар баримтлах төрийн бодлого: суурь судалгааны урьдчилсан тайлан Retrieved from
- НЗДТГ. (2014). Хүн амын амьжиргаа. Retrieved from
- Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн дизайн, үр шим хүртэгчдийн байдалд хийсэн дүн шинжилгээ. (2015). Retrieved from Улаанбаатар:
- НҮБХХ, & МУЗГ. (1994). Хөгжлийн хөтөлбөрт ядуурлыг бууруулах асуудлыг тусгах” сэдэвт үндэсний семинарын материал. Retrieved from Улаанбаатар:
- Өмч хувьчлалын явц, өнөөгийн байдал, цаашдын зорилтын тухай: УИХ. ын тогтоол. (1995). Засгийн газрын мэдээ.
- УИХТГ. (2015). Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого 2015-2040 төсөл. Retrieved from Улаанбаатар:
- ХАХНХЯ. (2012-2016). ХАХНХЯ-ны тайлан. Retrieved from Улаанбаатар:
- ШУА. (2014). Монгол дахь хотжилт: үйл явц ба төлөв байдал. Retrieved from Улаанбаатар:
- 冯立天, & 戴星翼. (1996). 中国人口生活质量再研究 (Vol. 4): 高等教育出版社.
- 世界银行, 蒙古国贫困现状特征 [A] 国家统计局, 2007—2008 年家庭经济社会调查 [C] 乌兰巴托, 2009年
- 蒙古国统计年鉴2017-2018, 乌兰巴托, 2018年
- 习近平, 摆脱贫困 [M], 海峡出版发行集团, 2014年
- 蒙古国人类发展报告 [M], 蒙古国政府, 乌兰巴托, 2016年
- 蒙古国失业与扶贫政策 [M], 蒙古国政府, 乌兰巴托, 2019年
- 国家统计局农调总队. 中国农村贫困标准研究——课题组的研究报告 [J]. 统计研究, 1990(6): 37-42.
- 雷诺兹. 微观经济学 [M]. 北京: 商务印书馆, 1993: 32.
- 孙建忠. 台湾地区社会救助政策发展之研究 [M]. 台北: 时英出版社, 2002: 64.

*Монгол улсын ядуурлын төрх ба түүнийг  
бууруулах тандалт судалгаа*

- 马丁·瑞沃林. 贫困的比较[M]. 北京：北京大学出版社，2005:97.  
1967: 86-94.
- 岳希明，李实，王萍萍，等. 透视中国农村贫困[M]. 北京：经济科学出版社，2007：74